



Багануур үйлдвэрлэл технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гэрээ



ГҮЙЦЭТГЭГЧ:
Санни трейд ХХК-ийн захирал
Г.Сэлэнгэ

Дугаар №НХААГ-19/115

2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (цаашид "захиалагч" гэх), нэгт талаас "Санни трейд" ХХК (цаашид "зөвлөх" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

- Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох "Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ"-нд заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) үзүүлэх үүрэгтэй.
- Зөвлөх нь захиалагчаас шаардаж буй мэргэжлийн дадлага туршлага, ажиллах хүчин болон техникийн эх үүсвэртэй бөгөөд гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу үйлчилгээг үзүүлэхийг хүлээн зөвшөөрсөн болно.
- Захиалагч нь "Багануур үйлдвэрлэл технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээ" хийх зөвлөх үйлчилгээ НХААГ-19/115-г (цаашид "ажил" гэх) 27,075,000 /Хорин долоон сая далан таван мянга/ төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн Зөвлөхийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Үүнээс техник хяналтын зардал 541,500 /Таван зуун дөчин нэгэн мянга таван зуу/ төгрөг. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Санхүүжилтийг гүйцэтгэлээр олгоно.
- "Багануур үйлдвэрлэл технологийн паркийн Байгаль орчны нөлөөллийн байдлын нарийвчилсан үнэлгээ" хийх НХААГ-19/115 дугаартай зөвлөх үйлчилгээг 2019 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр эхэлж, 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр дуусган хүлээлгэн өгнө.
- Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Ажлын даалгавар, үйлчилгээний цар хүрээ
 - Ажиллах хүчин-Туслан гүйцэтгэгч- Голлох мэргэжилтний ажлын хуваарь
- Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно.
- Захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзодуулж нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.